

Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын
22-ны өдрийн А/39 дүгээр тушаалын
14 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хот байгуулалт, хотын стандартын
газар

Нэгжийн нэр:

Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн
төлөвлөлтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Газар зохион байгуулалт, геодези зураг
зүйн асуудал хариуцсан ажилтан

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТУ-7

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо,
Наадамчдын зам 1200, Нийслэлийн Нутгийн
Захиргааны цогцолбор барилга

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Улаанбаатар хотын хэмжээнд өндөржилтийн нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулах,
хот байгуулалтын мэдээллийн сангийн баяжилт хийх, инженерийн шугам сүлжээний
өргөтгөл шинэчлэл, төслүүдийн байршил сонгох газар зохион байгуулалтын асуудлыг
зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулан гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргад
тайлагнана.

Албан тушаалын зорилт:

- 1.Инженерийн шугам сүлжээний геодезийн тодруулга гарган төлөвлөлтийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлэх, хяналт тавих.
- 2.Инженерийн шугам сүлжээний хангамжийн төлөвлөлтийн шатанд газрын байршлыг сонгон шийдэл боловсруулах, хэрэгжилтийг хангуулах.
- 3.Өндөржилтийн нэгдсэн төлөвлөлт, шугам сүлжээний жижүүрийн зургийг хөтлөх, хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх.
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Дэд бүтэц, өндөржилтийн нэгдсэн төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний геодезийн тодруулга, дэвсгэр зургийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх;	Шинээр төлөвлөж буй өндөржилтийн төлөвлөлт хийгдсэн байна.	Г
	2.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, техник, эдийн засгийн үндэслэлд санал өгч, өндөржилтийн нэгдсэн төлөвлөлт хийх, инженерийн шугам сүлжээний геодезийн тодруулга, дэвсгэр зургийн судалгаа гаргах, хэрэгжилтийг ханган ажиллах;	Өндөржилтийн нэгдсэн төлөвлөлтийн дагуу гүйцэтгэл хийгдсэн байна.	Г
	3.Шинээр баригдах хороолол, хотхоныг өндөржилтийн нэгдсэн төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний геодезийн тодруулга, дэвсгэр зургийн судалгаа шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоог үе шаттай гарган хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд санал өгч ажиллах;	Хөрөнгө оруулалтын төсөлд санал хүргүүлсэн байна.	Г
	4.Өндөржилтийн нэгдсэн төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний геодезийн тодруулга, дэвсгэр зургийн судалгааны зургийн даалгавар боловсруулах, баталгаажуулах, ажлын зураг төслийг зөвшилцөх, хэрэгжилтэд хяналт тавих.	Өндөржилт, геодезийн сүлжээний зургийн даалгавар, зураг төсөл батлагдаж хэрэгжсэн байна.	Г, Х

2 дугаар зорилтын хүрээнд	1.Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд өндөржилтийн нэгдсэн төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний геодезийн тодруулга, дэвсгэр зургийн судалгаа гаргах;	Инженерийн дэд бүтцийн шийдэл гарсан байна.	Г
	2.Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөж шинээр барихад өндөржилтийн нэгдсэн төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний геодезийн тодруулга, дэвсгэр зургийн судалгаа гаргах, хяналт тавьж ажиллах.	Инженерийн дэд бүтцийн зургийн даалгавар, зураг төсөл боловсруулагдсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Өндөржилтийн нэгдсэн төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний геодезийн тодруулга, дэвсгэр зургийн судалгаа гаргах, жижүүрийн зураг, байр зүйн зураг хөтлөх, хяналт тавих;	Норм дүрмийн дагуу төлөвлөлт батлагдсан байна.	Г, Х
	2.Инженерийн шугам сүлжээний байр зүйн зураг, нэгж талбарт ерөнхий төлөвлөгөөний өндөржилт, төлөвлөлтийн ажлын зураг төслийг нэгтгэн жижүүрийн зураг хөтлөх, хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд бүртгэх.	Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд шугамын мэдээлэл орсон байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албаны стандартыг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, газрын дотоод журмыг мөрдөн ажиллах;	Холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажилласан байна.	Г, Х
	2.Албан тушаалын тодорхойлолт, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ биелүүлж, тайлагнаж ажиллах;	Зохих журмын дагуу тайлагнаж ажилласан байна.	Г
	3.Иргэн, хуулийн этгээдээс ирсэн өргөдөл гомдол, албан бичгийг судлан хугацаанд нь чанартай шийдвэрлэх, гүйцэтгэлд хяналт тавих;	Зохих журмын дагуу зохион байгуулж, хянаж, тайлагнасан байна.	Г, Х, Ш
	4.Архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдох хууль журмыг мөрдөн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу үүссэн баримт бичгийг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөх, хяналт тавих;	Зохих журмын дагуу зохион байгуулж, хянаж тайлагнасан байна.	Г, Х

	5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- геодези /053201/; - газар зохион байгуулалт /073101/; - газрын кадастр /073103/.		
Мэргэшил	Харгалзахгүй		
Туршлага	Харгалзахгүй		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - албан үүргээ гүйцэтгэх явцад гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх; - багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - бүтээлч санаачилгатай ажиллах; - бусад.	
	Бусад	- AutoCAD, ArcGIS зэрэг программ эзэмшсэн байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх чадвартай байх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх.	

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан;
- төрийн болон төрийн бус байгууллага;
- иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

..... (Д.ДАШЦЭЦЭГ)
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн
нэр)

2024 оны 07 дугаар сарын 22-ны өдөр

Албан тушаал
ДАРГА
(тамга/тэмдэг)

..... (Г.БАТЗОРИГ)
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн
нэр)

2024 оны 07 дугаар сарын 22-ны өдөр